

МАТАД СУМЫН ЕБС-ИЙН 7-Р АНГИЙН АНГИ ДЭВШИХ МОНГОЛ ХЭЛНИЙ
НЭГДМЭЛ ШАЛГАЛТЫН СЭДЭВ

Гүйцэтгэх хугацаа- 60 минут

Нийт оноо 20

Сурагчийн нэр.....

Б ХУВИЛБАР

- Эхийг анхааралтай уншаад, даалгаврыг гүйцэтгэнэ үү.

ХӨРӨГ НАЙРУУЛАЛ

Модод гөлөглөчихжээ. Цоо шинэхэн, гэрэлтсэн ногоон өнгөтэй нахианууд хачин уярам сэтгэгдэл төрүүлэхэд, яагаад ч юм бэ, намхан биетэй, буурал толгойтой, үргэлж л нүүрэндээ мишээл тодруулан намайг угтдаг эмээ минь бодогдов...

Эмээ уншиж чаддаггүй байсан юм. Аймгийн төвд орж ирснийхээ дараа радио их сонсдог болжээ. Эмээ минь дуучдыг хоолойгоор нь андахгүй таньдаг, тэр үеийн улсуудын удирдагчдын нэрс, за тэгээд, аль нь социалист, аль нь хөрөнгөтөн орон болохыг ялгаж мэддэг авай. Эмээ их олон үлгэр мэддэг байсан мөртлөө, яагаад ч юм бэ, надад ерөөсөө ярьж өгч байгаагүй. Гэхдээ эмээ минь "Гучин хоёр модон хүн"-ий үлгэрийг харин бүгдийг нь мэддэг.

Эмээ дууг бол харин зааж өгдөг байлаа. Тухайн үед ихэд дэлгэрч, хэн хүнгүй аялдаг болчихсон дууны үгийг надад зөвтгөн хэлж өгдөг хүн ганцхан эмээ л байсан юм... Намайг ухаан суухын хэрээр эмээгийн хоолой аргиж, би "Дааган хар" хэмээх дууны өөр аль ч нутагт дуулдаггүй бэсрэгдүүхэн аяыг л цээжилж амжсан. Заримдаа "Дааган хар"-ыг эмээгийнхээ аялдаг барилаар аялж үзэхдээ ерөөсөө өөр нэг ч хүн энэ дууг ингэж дуулдаггүй байх гэж боддог юм. ...

1. Гадаад шинжийг тодруулан гаргасан тэмдэг нэрсийг түүж, дотоод шинжийг дүгнэн бичээрэй. \2оноо\

Гадаад шинж	Дотоод шинж

2. Дээрх эхийн үйл явдал ямар улиралд болж байна вэ? \2 оноо\

.....

Ямар өгүүлбэрээр илэрхийлэгдэж байна вэ?

.....

3. Дараах үгийн утгыг тайлбарлан бичнэ үү. \2 оноо\

А. Хэргэм-

Б. Цээжээ уудлах-

4. Дараах тэмдэг нэрийг харьцуулсан зэрэгт хувирган бичээрэй. 12 оноо

Тэмдэг нэр ногоон	Ижил зэрэг	Илүү зэрэг

4. Зөв бичгийн дүрмийг тайлбартай нь зөв харгалзуулна уу? 12 оноо

- | | |
|------------------------------------|-------------------------------------|
| 1. Гээгдэхгүй эгшгийн дүрэм | а. Бодлоос, эцгийн, сурагчдад, |
| 2. Зөөлний тэмдэг и болох | б. Соливол, сахилаа, тавих |
| 3. Гээгдэх эгшгийн дүрэм | в. Аньсага, жинхэнэ, оньсого |
| 4. Дараалсан 3 гийгүүлэгчийн дүрэм | д. Тайлбарыг, засвараас, хамтралаар |
5. Зохиолыг гол дүртэй нь зөв харгалзуулаарай.

- | | |
|--|------------------------------------|
| 1. Я.Кавабата “Ангийн даргын мөрдөлт” | а.Өвгөн, жаалхүү, аварга том загас |
| 2. Ү Чэнь-энь Тансан лам баруун этгээдэд зорчсон тэмдэглэл | б. Рон, Хермиони, Дамблдор, Хагрид |
| 3. Д.Цэвэгмид “Алагдай аварга” | в. Эрээдэй, Орогдой, Өвгөн сэрх |
| 4. Э.Хэмингуэй “Өвгөн тэнгис хоёр” | г. Шинкичи, Кимүра, Фүмио, Сэйчи |
| 5. Ж.К.Роулин “Харри Поттер” | д. Сүн Үкүн, Жү Ба-жэ, Шасэн |

7. Дараах өгүүлбэрийг уншаад хөрвүүлэн бичээрэй. 15 оноо

Өмнөхөн үзүүлсэн бүтээлүүдэд
 Өмнөхөн үзүүлсэн бүтээлүүдэд
 Өмнөхөн үзүүлсэн бүтээлүүдэд
 Өмнөхөн үзүүлсэн бүтээлүүдэд
 Өмнөхөн үзүүлсэн бүтээлүүдэд
 Өмнөхөн үзүүлсэн бүтээлүүдэд

.....

.....

.....

БАТЛАВ
ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Ө.ЦЭВЭЭНСҮРЭН

МАТАД СУМЫН ЕБС-ИЙН 7-Р АНГИЙН АНГИ ДЭВШИХ МОНГОЛ ХЭЛНИЙ
НЭГДМЭЛ ШАЛГАЛТЫН СЭДЭВ

Гүйцэтгэх хугацаа- 60 минут
Сурагчийн нэр.....

Нийт оноо 20

А ХУВИЛБАР

- Эхийг анхааралтай уншаад, даалгаврыг гүйцэтгэнэ үү.

МУМУ

Герасим гөлгөө хайрлан хамгаалах нь хүн хүүхдээ арчлан хамгаалахаас илүү ажээ. ...Тэр гөлөг анхандаа сул биетэй, муухай, ядрангүй байсан боловч аажмаар өнгө зүс орж, тэнхрээд найман сар болсны дараа асрагчийнхаа зогсолтгүй арчлан хамгаалахын ачаар аятайхан хөөрхөн нохой болов. Урт чихтэй, сагсгар сүүлтэй, ухаалаг нүдтэй, испани үүлдрийн нохой ажээ. Тэгээд Герасимд тун их дасаж, түүнээс нэг алхам холдохгүй, сүүлээ шарвагнуулан дагаж гүйдэг болжээ.

....Муму Герасимыг өглөө болгон хормойноос нь татаж сэрээдэг, бас тэрэгний хөгшин морийг жолооноос нь хөтлөн авчирч, Герасимтай хамт гол руу ихэмсэг байдалтай явж, түүний шүүр хүрзийг манаж, байшинд нь хэнийг ч эс ойртуулдаг ажээ. ...Муму шөнө ер унтахгүй боловч өлийгөөд тэнгэрийн од харж дэмий л ян ян хуцдаг муу сайн нохойтой адил хий хоосон хуцдаггүй ажээ.

1. Муму түүний шинжийг бичээрэй. \2 оноо\

Өмнө нь	Дараа нь

2. Гөлөг Герасимд яагаад дассан бэ? \2 оноо\

.....

- Мумугийн эзэндээ үнэнч, хоточ нохой гэдгийг илэрхийлсэн хэсгийг бичнэ үү.

.....

3. Дараах үгийн утгыг эхээс уншиж, хам сэдвийн хүрээнд тайлбарлан бичнэ үү. \2 оноо\

А. асган-

Б. Цээжээ хавтаслах-

4. Дараах тэмдэг нэрийг харьцуулсан зэрэгт хувирган бичээрэй. \2 оноо\

Тэмдэг нэр хүйтэн	Илүү зэрэг	Давуу зэрэг

5. Зөв бичгийн дүрмийг тайлбартай нь зөв харгалзуулна уу? \2 оноо\

- | | |
|------------------------------------|------------------------------------|
| 1. Гээгдэхгүй эгшгийн дүрэм | а. тэнхрээд, эцгийн, сурагчдад, |
| 2. Зөөлний тэмдэг и болох | б. Соривол, тахилаа, харих |
| 3. Гээгдэх эгшгийн дүрэм | в. Чагтага, жинхэнэ, хундага |
| 4. Дараалсан 3 гийгүүлэгчийн дүрэм | д. Талбарыг, засвараас, нягтралаар |

5. Д.Нацагдоржийн “Миний нутаг” шүлгийн хэсгийн нөхөж бичээрэй. /5 оноо/

- | | |
|---|-------------------------------------|
| 1. Д.Цэвэгмид “Алагдай аварга” | а. Өвгөн, жаалхүү, аварга том загас |
| 2. Ү Чэнь-энь Тансан лам баруун этгээдэд
Зорчсон тэмдэглэл | б. Рон, Хермиони, Дамблдор, Хагрид |
| 3. Я.Кавабата “Ангийн даргын мөрдөлт” | в. Эрээдэй, Орогдой, Өвгөн сэрх |
| 4. Э.Хэмингуэй “Өвгөн тэнгис хоёр” | г. Шинкичи, Кимүра, Фүмио, Сэйчи |
| 5. Ж.К.Роулин “Харри Поттер” | д. Сүн Үкүн, Жү Ба-жэ, Шасэн |

7. Дараах өгүүлбэрийг уншаад хөрвүүлэн бичээрэй.

ᠮᠠᠨᠤ ᠤᠯᠤᠰᠤ ᠤᠯᠤᠰᠤ ᠤᠯᠤᠰᠤ
ᠮᠠᠨᠤ ᠤᠯᠤᠰᠤ ᠤᠯᠤᠰᠤ ᠤᠯᠤᠰᠤ
ᠮᠠᠨᠤ ᠤᠯᠤᠰᠤ ᠤᠯᠤᠰᠤ ᠤᠯᠤᠰᠤ
ᠮᠠᠨᠤ ᠤᠯᠤᠰᠤ ᠤᠯᠤᠰᠤ ᠤᠯᠤᠰᠤ
ᠮᠠᠨᠤ ᠤᠯᠤᠰᠤ ᠤᠯᠤᠰᠤ ᠤᠯᠤᠰᠤ
ᠮᠠᠨᠤ ᠤᠯᠤᠰᠤ ᠤᠯᠤᠰᠤ ᠤᠯᠤᠰᠤ
ᠮᠠᠨᠤ ᠤᠯᠤᠰᠤ ᠤᠯᠤᠰᠤ ᠤᠯᠤᠰᠤ
ᠮᠠᠨᠤ ᠤᠯᠤᠰᠤ ᠤᠯᠤᠰᠤ ᠤᠯᠤᠰᠤ

.....

.....

.....